

БАТЛАВ.

МОНГОЛ УЛСЫН САЙД,  
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ  
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА

Л.ОЮУН-ЭРДЭНЭ

БАТЛАВ.

САНГИЙН САЙД

Ч.ХҮРЭЛБААТАР

БАТЛАВ.

ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД  
ХЭРГИЙН САЙД

Ц.НЯМДОРЖ

**НИЙСЛЭЛИЙН ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛИЙН  
ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСЛИЙН  
ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

**Нэг. Хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлага**

Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах дараахь хууль зүйн үндэслэл, практик шаардлага байна. Үүнд:

**1.1.Хууль зүйн үндэслэл**

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван гуравдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улсын төрийн дээд байгууллагууд байнга оршдог хотыг Улсын нийслэл гэнэ. Монгол Улсын нийслэл Улаанбаатар хот мөн.”, 2 дахь хэсэгт “Монгол Улсын нийслэлийн эрх зүйн үндсийг хуулиар тогтооно.” гэж;

“Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлэх, түүнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын 2020 оны 1 дүгээр сарын 9-ний өдрийн 02 дугаар тогтоолын хавсралтын “Дөрөв.Нутгийн удирдлагатай холбоотой нэмэлт, өөрчлөлт” гэсэн хэсэгт “Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулна.” гэж;

Монгол Улсын Их Хурлын 2017 оны 11 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын хууль тогтоомжийг 2020 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”-ийн 115-д “Хот нийгэм, эдийн засгийн хувьд бие даан хөгжих хөшүүргийг бий болгох, төвлөрлийг сааруулах чиглэлээр холбогдох зохицуулалтыг нэмж тусгах, нийслэлийн удирдлагын эрх зүйн байдлыг боловсронгуй болгох зорилтын хүрээнд Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж, батлах” гэж;

Улсын Их Хурлын 2016 оны 45 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 5.1.21-д “Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тогтолцоо, эрх хэмжээ, чиг үүрэг, үйл ажиллагааны зарчим, зохион байгуулалтыг боловсронгуй болгоно.”, 2.86-д “Улаанбаатар хотыг хөгжүүлэх эрх зүйн орчинг бүрдүүлнэ.” гэж;

Улсын Их Хурлын 2013 оны 23 дугаар тогтоолоор баталсан “Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 он хүртэлх

хөгжлийн чиг хандлагын баримт бичиг"-т тусгагдсан "Улаанбаатар хотыг нэг төвт хотоос олон төвт, орчин үеийн хот болгон хөгжүүлэх, хүн амын төвлөрлийг сааруулж нийслэлийн дагуул, хаяа хот, тосгодыг хөгжүүлэх" зорилтуудыг тодорхойлох зэргээр тус тус заасан байна.

## **1.2.Практик шаардлага**

Монгол Улсын нийслэл Улаанбаатар хот нь 380 гаруй жилийн түүхтэй бөгөөд Улсын Их Хурлаас анх 1994 оны 7 дугаар сарын 5-ны өдөр Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хуулийг батлан гаргасан. Өнөөгийн байдлаар нийслэл, түүний удирдлагын чиг үүргийг тогтоосон 130 гаруй хууль хүчин төгөлдөр үйлчилж байгаагаас өдөр тутмын үйл ажиллагааг зохицуулсан 20 гаруй хууль үйлчилж байна.

Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хууль батлагдсанаас хойшхи 26 жилийн хугацаанд нийслэл хотын үйл ажиллагаа бүхий л салбарт байнга өргөжин хөгжиж ирсэн.

Нийслэл нь 1995 онд 9 дүүрэг, 117 хороотой байсан бол 2020 онд хорооны тоо 173 болж, 609.9 мянган хүн амтай байсан Улаанбаатар хот өдгөө 1.444.7 мянга гаруй болсон нь Монгол Улсын нийт хүн амын 45.3 хувийг эзэлж байна.

Мөн нийслэлд өнөөгийн байдлаар нийт 126.421 аж ахуйн нэгж, байгууллага бүртгэлтэй байгаа нь улсын хэмжээнд бүртгэлтэй байгаа аж ахуйн нэгж, байгууллагын 74.3 хувь болж байна.

Нийслэлийн дотоодын нийт бүтээгдэхүүн 2018 онд 21.404.4 тэрбум төгрөгт хүрсэн нь үндэсний дотоодын нийт бүтээгдэхүүний<sup>1</sup> 66.25 хувьтай тэнцэж байна.

Улаанбаатар хотын хүн амын хэт өсөлт нь хот байгуулалт, төлөвлөлт, байгаль орчин, экологийн аюулгүй байдалд сөргөөр нөлөөлж, төлөвлөлтгүй суурьшил бий болох, замын хөдөлгөөний түгжрэл үүсэх, хүн амын эрүүл мэнд, нийгмийн халамж, үйлчилгээний салбар догоход зэргээр эдийн засаг, нийгмийн бүх талын харилцаанд хүндрэл учруулах болсон тул төрөөс оновчтой бодлого боловсруулж, хэрэгжүүлэх шаардлагатай байна.

1994 онд батлагдсан Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хуулийн зүйл, заалт цаг хугацааны явцад зохицуулалтын чадвараа алдаж, нөгөө талаас хуулиар зайлшгүй зохицуулах шаардлагатай нийгмийн зарим харилцаа үүсэж эрх зүйн хийдлийг бий болгож байна.

Иймд дээр дурдсан үндэслэл, шаардлагыг харгалзан Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж, батлуулах шаардлагатай байна.

## **Хоёр.Хуулийн төслийн зорилго, ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ**

Хууль тогтоомжийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1.2, 25.1.3-т заасныг үндэслэн зарим зүйл, заалтыг хүчингүй болгох, шинээр зүйл заалт нэмэх зэргээр

<sup>1</sup> Үндэсний дотоодын нийт бүтээгдэхүүний хэмжээ 32.307.32 тэрбум төгрөг байна.

хуулийн тавиас дээш хувьд нэмэлт, өөрчлөлт орж байгаа тул тус төслийг шинэчилсэн найруулгын хэлбэрээр боловсруулна.

Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хуулийн зорилт нь Монгол Улсын нийслэлийн чиг үүрэг, түүнийг хэрэгжүүлэх эдийн засгийн үндэс, нийслэлийн оршин суугчийн эрх, үүрэг, нийслэлээс оршин суугч, аж ахуйн нэгж, байгууллага болон засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бусад нэгжтэй харилцах эрх зүйн үндсийг тодорхойлоход оршино.

Хуулийн төсөлд дараахь асуудлыг тусгана:

1/ Нэгдүгээр булэгт нийтлэг үндэслэл буюу хуулийн зорилт, нийслэлийн эрх зүйн байдлын тухай хууль тогтоомж, нийслэл, түүний чиг үүрэг, нутаг дэвсгэр, эдэлбэр газар, бэлгэ тэмдэг зэргийг тусгана.

2/ Хоёрдугаар булэгт нийслэлийн хөгжлийн бодлого, эдийн засгийн үндэс, нийслэлийн төсөв, нийслэлийн татвар, нийслэлийн өмч, нийслэлийн өмчит хуулийн этгээд, нийслэлийг хөгжүүлэх сангийн талаар тусгана.

3/ Гуравдугаар булэгт нийслэл хотын дүрэм, нийслэлийн нутаг дэвсгэрт төрийн үйлчилгээ үзүүлэх хялбаршуулсан журмын талаар тусгана.

4/ Дөрөвдүгээр булэгт нийслэлийн оршин суугч, түүний эрх, үүргийг тусгана.

5/ Тавдугаар булэгт нийслэлийн удирдлагын тогтолцоо, тэдгээрийн бүрэн эрх, үйл ажиллагааны зарчим, нийслэлийн судалгааны байгууллагын талаар тусгана.

6/ Зургадугаар булэгт дүүрэг, хорооны эрх зүйн байдлын талаар тусгана.

7/ Долдугаар булэгт нийслэлээс төрийн захиргааны төв байгууллага, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бусад нэгж, аж ахуйн нэгж, байгууллагатай харилцах болон төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжээс нийслэлийн өмнө хүлээх үүргийн талаар тусгана.

8/ Наймдугаар булэгт нийслэлийн талаархи Улсын Их Хурал, Засгийн газраас хэрэгжүүлэх бүрэн эрхийн талаар тусгана.

9/ Есдүгээр булэгт нийслэлийн өдөр, нийслэлийн шагналын талаар тусгана.

10/ Араевдугаар булэгт нийслэлийн нутаг дэвсгэрт хориглох үйл ажиллагаа, хууль тогтоомж зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага, хууль хүчин төгөлдөр болох талаар тусгана.

**Гурав.Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсч болох нийгэм, эдийн засаг, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал**

Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл батлагдсанаар дараахь нийгэм, эдийн засаг, хууль зүйн үр дагавар гарна. Үүнд:

1. Нийслэлийн санхүүгийн чадавхийг бэхжүүлэх, нийслэлийн төсвийг иргэдийн эрх, ашиг сонирхолд нийцүүлэн захиран зарцуулах, нийгэм, эдийн засгийн тулгамдаж байгаа асуудлыг эдийн засгийн аргаар буюу албан татвар, төлбөр тогтоох, хөнгөлөлт үзүүлэх, чөлөөлөх замаар шийдвэрлэх боломжийг нэмэгдүүлж, ингэснээр улс, эх орны эдийн засагт эерэг нөлөө үзүүлнэ. Тухайлбал:

-Нийслэлийн албан татвар, төлбөрийн төрөл, хэмжээг хэрхэн тогтоох, хөнгөлөх, чөлөөлөх нөхцөл бүрдэнэ;

-Нийслэлийн төсвийн орлогыг зөвхөн хуульд заасан нийслэлийн чиг үүргийг хэрэгжүүлэхэд зарцуулна;

-Нийслэлийн хэт төвлөрлийг сааруулж, дагуул хотуудыг хөгжүүлэх үйл ажиллагааг төрөөс татварын бодлогоор зохицуулах эрх зүйн орчин бүрдэнэ;

-Нийслэл нь өөрийн өмчид үндэслэн стратегийн ач холбогдолтой хөгжлийн төсөл, хөтөлбөрийг санхүүжүүлэхэд үнэт цаас гаргах эрх зүйн орчин бүрдэнэ гэх мэт.

2. Нийслэл хот дүрэмтэй болж иргэддээ чиглэсэн, нийтийн эрх ашигт нийцсэн, иргэдийн эрүүл, аюулгүй, тав тухтай оршин суух орчныг бүрдүүлнэ. Ингэснээр хууль тогтоомжоор зохицуулагдаагүй асуудлууд иргэдийн оролцоотойгоор шийдвэрлэгдэх эерэг нөлөө үзүүлнэ.

3. Нийслэлийн оршин суугч иргэн, хуулийн этгээдийн эрх, үүрэг тодорхой болж нийслэлийн хөгжилд оршин суугчдын оролцоо нэмэгдэх, нийслэлийн нутгийн захиргааны байгууллагууд оршин суугчдад тулгуурласан үйл ажиллагаа явуулах боломж бүрдэнэ. Ингэснээр иргэд үндсэн эрхээ эдлэх хууль зүйн баталгааг хангахад эерэг нөлөөтэй. Тухайлбал:

-нийслэлийн оршин суугч нь орчноо тохижуулах, нийслэлийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд хувь нэмэр оруулсны төлөө урамшуулал хүртэх, эрүүл аюулгүй орчин, дэд бүтцийн үйлчилгээгээр хангагдана;

-иргэд зөвхөн хотын хөгжлийн өрөнхий төлөвлөгөөнд тусгагдсан бүсэд суурьшин амьдрах, орчноо тохижуулах, хуульд заасан төлбөр, хураамж төлөх зэрэг үүрэг хүлээнэ;

-нийслэлийн нутаг дэвсгэрт төлөвлөлтгүй газар суурьшил үүсгэх болон суурьших, зөвшөөрөлгүйгээр газар эзэмших, ашиглах, барилга угсралтын ажил явуулах, бусдын орц, гарцыг хаах, зөвшөөрөгдөөгүй бүсэд мал аж ахуй эрхлэх зэргийг хязгаарлаж эмх цэгцтэй болох боломж бүрдэнэ;

-үүргээ биелүүлээгүй, хориглосон үйл ажиллагаа явуулсан тохиолдолд хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ гэх мэт.

4. Манай улсын нийт хүн амын тал хувь нь оршин сууж, үндэсний дотоодын нийт бүтээгдэхүүний 66.2 хувийг үйлдвэрлэж буй Нийслэл нь бусад засаг захиргааны нэгжээс бүтэц, тогтолцоо, чиг үүрэг, хариуцлага, ажлын ачааллын хувьд ялгаатай болохыг тогтоосноор чиг үүргийн давхардал, хийдэл арилах, Нийслэл, дүүрэг, хорооны эрх зүйн байдал тодорхой болно. Тухайлбал:

-Дүүрэг дагуул хотын статустай болох боломж, нөхцөлийг бурдүүлнэ;

-Хороо төсөвтэй болно;

-Улаанбаатар хотын Захирагчийн Ажлын албаны чиг үүрэг нэмэгдэж, Нийслэлийн Засаг даргын төрийн болон аж ахуйн чиг үүрэг зааглагдана;

5. Нийслэлийн нутаг дэвсгэрт төрийн зарим үйлчилгээг хялбаршуулсан журмаар үзүүлэх, иргэн, хуулийн этгээд төрийн үйлчилгээг шуурхай авах эрх зүйн орчин бурдэнэ. Мөн хуулиар зөвшөөрөл шаардагдах аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх иргэн, хуулийн этгээдэд зохих зөвшөөрлийг хууль тогтоомжийн дагуу түргэн шуурхай, чирэгдэлгүй олгох боломж бүрдэж, улс, орон нутгийн төсөвт эерэг нөлөө үзүүлэх ач холбогдолтой.

**Дөрөв. Хуулийн төсөл Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуулттай хэрхэн уялдах, хуулийг хэрэгжүүлэхэд шинээр боловсруулах, хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох тухай хууль тогтоомжийн талаарх санал**

Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, бусад хууль тогтоомжтой нийцэх бөгөөд хуулийн төсөлтэй холбогдуулан Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай, Үл хөдлөх хөрөнгийн албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Татварын өрөнхий хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай, Өрийн удирдлагын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай зэрэг холбогдох шаардлагатай бусад дагалдах хуулийн төслүүдийг боловсруулна.

**-ооОоо-**